XII/06

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ҮЙЛЧЛЭГЧ Б.СЭРЧМААГИЙН

2024 ОНЫ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024.12.05

| Д/Д | Хийж гүйцэтгэх ажил | Ажлын гүйцэтгэл |
|---|---|---|
| 1 | Байгууллагын доторхи өрөөнүүд 1, 2, 3 давхруудын заал, коридор, архивын өрөө, цонхны тавцангийн цэвэрлэгээг тогтмол хийнэ. | Цэвэрлэгээг өдөрт 2-3 удаа хийж, 7 хоногт 2 удаа их цэвэрлэгээ хийдэг, 1-2 удаа хлорминжуулж тоос шороог тогтмол арчдаг. Ажлын байраа цэвэр цэмцгэр байлгахын тулд өдөрт 1-2 удаа чийгтэй цэвэрлэгээ хийж байна. Хамт олноороо байгууллагын коридор болон өрөөнүүдэд эмүс хийж, их цэвэрлэгээг хийсэн. Архивын үүдний сангийн паарыг солиход гоожсон усыг арчиж цэвэрлэсэн. Стадион дээр хамт олонтойгоо сандал цэвэрлэсэн. |
| 2 | Ажилчдын ширээ сандлыг арчиж ажилдаа ирэхэд нь бэлдэнэ. | Ажилчид албан хаагчдын тав тухай орчин бүрдүүлэхийн тулд өглөө 8-8:30-ын хооронд ажилдаа ирж, ажилчдын ширээ, компьютерийн тоосыг арчиж, халдваргүйжүүлдэг. Өдөр бүр цайны цагаар чийгтэй цэвэрлэгээ хийж, ажилчдын хогийн саван дахь хогийг авдаг. 17-18 цагийн хооронд чийгтэй цэвэрлэгээг тогтмол хийдэг. |
| 3 | Ариутгалыг бодис хлормины уусмалаар ариутгаж цэвэрлэгээг тогтмол хийх | Хэлтсийн өрөөнүүдийн хаалга болон бариул, шатны бариул, цонхны тавцан, коридорыг тогтмол белизнатай усаар ариутгаж өдөр бүр чийгтэй цэвэрлэгээ хийдэг. |
| 4 | Байгууллагын хогийг хуваарьт өдөр нь ачуулна. | Байгууллагын хогийг 3 дахь өдөр нь ачуулж складны хог хаягдлыг харуул, нярав нартай хамтран цэвэрлэсэн.<br>2024.01.03-ны өдөр грашт цэвэрлэгээ хийсэн.<br>2024.04.09-10 хооронд граш, складруу цасны ус орж эд зүйлсийг хамт олноороо зөөж байршуулж, хог хаягдлыг хогийн машинд ачуулсан. |
| 5 | Хэлтсээс зохион байгуулж байгаа “Нээлттэй хаалганы өдөр” болон хурал | 2024.05.07 Хурлын заалны 3 ширхэг чүүлийг угааж индүүдэн зүүсэн.<br>“Хуулчдын пороро” өдөрлөгт ширээ сандал зөөж, тоосыг нь арчиж |

| | | |
|---|---|---|
| | цуглааны үеэр хурлын заалны ширээ сандлыг арчиж цэвэрлэнэ. | цэвэрлэсэн. |
| 6 | Ажлын багаж хэрэгсэл нормын хувцсыг ашиглалтын хугацаанд ариг гамтай ашиглана. | Ажлын хувцсыг 2022-2024 оны хооронд өмсөж байна. Ажлын багаж хэрэгсэл нормын хувцсыг зориулалтын дагуу ариг гамтай ашиглаж байна. |
| 7 | Байгууллагын дарга удирдлагуудын зүгээс өгсөн үүрэг даалгавруудыг цаг тухайд нь биелүүлж хамт олны ажилд идэвхитэй оролцоно. | Байгууллагын дарга удирдлагуудын зүгээс ирсэн үүрэг даалгавруудыг цаг тухайд нь биелүүлж байна. Хуучин 1 давхарын зааланд байрлаж байсан эд хөрөнгийг байцаагч ажилчдын хамт зөөн байршуулсан. Үйлчилгээний тасгийн даргын өрөөний завсарыг хийсний дараа их цэвэрлэгээ хийж, тавилгыг зөөж оруулсан. Мөн ажлын хэсгийнхэнтэй хамт хувийн хэргийн эмх цэгцийг сайжруулан хавтсыг скочидож шкафт хийсэн.<br>2024.01.19 ажилчдын хамт байгууллагын хуваарьт талбайн цасыг цэвэрлэсэн. Баярсайхан гишүүн болон Бямбацогт сайдын уулзалтанд хамт олноороо суусан.<br>2024.04.16 Байгууллагын гадаад талбайн 50м орчимын хогийг хамт олонтойгоо цэвэрлэсэн. Мөн мод тарьж, зүлэг суулгасан.<br>Бүх нийтийн хог цэвэрлэх үйл ажиллагаанд ажилчдын хамт оролцон хувиарт газраа цэвэрлэсэн.<br>2024.08.22-23 хооронд архивт сангийн ажил хийхэд архивын баримтыг 3 давхрын зааланд зөөж, үлдсэн баримтыг гялгар цаасаар хамгаалалт хийсэн.<br>2024.08.30 шинээр шат хийсний дараа үүдний шатыг шойтогдож угаасан.<br>Харуулыг амрах хугацаанд сангийн ажил, хаалга цонх, паар солих үед гоожсон ус, бохирдлыг арчиж цэвэрлэсэн.<br>2024.08.31-09.01-ний хооронд үүд, шаланд цутгалт хийхэд ажиллаж цэвэрлэгээ хийсэн.<br>2024.09.02-нд НХ-ын байцаагчийг 2 давхарт нүүлгэн шилжүүлж, Лувсандондов байцаагчийг өрөөнд оруулан тохижуулсан.<br>2024.09.05 зааланд байсан баримтыг Мягмарсүрэн байцаагчтай хамт архивт зөөн байршуулсан.<br>2024.09.10 Сангийн ажил дууссаны дараа зэв болж халтардсан хэсгийг архивын үүдний өрөөтэй хамт эмьулсдсэн. Архивын үүдний жижиг өрөөг Нансалмаа, Мягмарсүрэн нартай хулдаасласан. |

| | | |
|---|---|---|
| | | 2024.09.13 нд Балжиннямтай хамт доод заалны 1 ширээг салган складанд хийсэн.<br>2024.18-19 хооронд ЕГ-с ирүүлсэн гарын авлага, борешурыг 23 суманд хуваирлан явуулсан.<br>2024.09.20 Улсын хэмжээний Нээлттэй хаалганы өдөрт ширээ сандал, асар зэргийн хамт олонтойгоо оролцсон.<br>2024.11.18-19 хооронд Улсын байцаагчийн шалгалтад орох байцаагчдад 2 баг болон 2-3 өдөр хоол, цай хийж өгсөн.<br>2024.11.27-28 өдрүүдэд НДГ-ын шагналын буланг угааж, цэвэрлэн тохижуулсан.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан шатны хуурсан хулдаасыг харуулын хамт наасан.<br>Өдрийн цайны цагаар сумдаас ирсэн бичгүүдийг хүний нөөцийн ажилтанд тухай бүр хүлээлгэн өгдөг.1,2-р давхрын суултуурын тагыг сольсон. |
| 8 | Өрөөнүүдийн ус буцалгагчийг цэвэрлэнэ. | Ус буцалгагчийг өдөр бүр тогтмол цэвэрлэн ариутгадаг. |
| 9 | Ажилтнуудын өрөө тасалгаанд агааржуулалт хийнэ. | Өрөө тасалгааг өглөө бүр агааржуулалт хийдэг. |
| 10 | Их цэвэрлэгээ хийх | Ковидын үед халдвараас урьдчилан сэргийлсэн 1,2 давхрын заалны шалны наалт, 2 самбарын цаасыг хуулж цэвэрлэгээ хийж хэвийн болгосон. Архивын үүдний саарал сефийг султган хогийг авч тоосыг арчсан.<br>2024 оны 4 сард саарал шкафыг 3 давхраас 1 давхарт зөөж, жижиг шар ширээг цэвэрлэн байршуулсан. |
| 11 | Байгууллагын цэцгийг хариуцан усалж, арчилна. | Байгууллагын цэцгийг 7 хоногт 2-3 удаа арчилж, усалдаг. 2024 онд шинээр 2 онгоцонд 10 ширхэг цэцэг тарьсан.Гадна үүдний зэрлэгийг зулгааж хогийн машинд ачуулсан. |
| 13 | Байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн хууль, гэрээний нөхцлийг нарийн чанд мөрдөж хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах | Байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн хууль, гэрээний нөхцлийг нарийн чанд мөрдлөг болгон ажиллаж байна. |
| 14 | Хэлтсийн бүх өрөөний хаалгыг арчиж халдваргүйжүүлнэ. | Хэлтсийн бүх өрөөний хаалгыг өдөр бүр арчиж, халдваргүйжүүлж байгаа. |

| | | |
|---|---|---|
| 15 | Хэлтсийн өрөөнүүдийн цонх болон коридорын цонх, шат зэргийг арчиж цэвэрлэнэ. | Өдөр бүр чийгтэй цэвэрлэгээ хийж тогтмол арчиж хэвшсэн. |
| 16 | Ариун цэврийн өрөөг арчиж цэвэрлэн халдваргүйжүүлэн, ариутгана. | Ариун цэврийн өрөөг өдөр бүр белизна болон жавелинтой усаар тогтмол арчиж цэвэрлэдэг. |

Тайлан бичсэн: Б.Сэрчмаа Б.Сэрчмаа